



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/532

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд түүхэн аялал жуулчлалыг илэрхийлэх гар урлал, бэлэг дурсгал, идээ ундааны нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, орон нутгийн иргэдийн орлого, аялал жуулчлалын нэмүү өртгийн сүлжээг нэмэгдүүлэх зорилготой зохион байгуулж буй "Нутгийн брэнд, гар урлалын үйлдвэрлэлийг аялал жуулчлалын бүдээгдэхүүн болгох нь" сургалтын зардалд 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012477

**"НУТГИЙН БРЭНД, ГАР УРЛАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
 БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОХ НЬ" СУРГАЛТЫН ТӨСӨВ**

| № | Зардлын нэр, төрөл                                                                            | Тоо<br>хэмжээ     | Нэг<br>бүрийн<br>үнэ | Бүгд үнэ  | Эх үүсвэр             |
|---|-----------------------------------------------------------------------------------------------|-------------------|----------------------|-----------|-----------------------|
| 1 | Сургагч багш, судлаачдын<br>сургалтын төлбөр                                                  | 4 багш * 5<br>цаг |                      | 2,000,000 | АЗДҮАХ-<br>ийн зардал |
| 2 | Өдрийн хоол                                                                                   | 60 хүн            | 15,000               | 900,000   | АЗДҮАХ-<br>ийн зардал |
| 3 | Цайны завсарлага                                                                              | 60 хүн            | 4,500                | 270,000   | АЗДҮАХ-<br>ийн зардал |
| 4 | Үйл ажиллагааны халдвар<br>хамгааллын зардал /Амны<br>хаалт, ариутгалын бодис,<br>бээлий г.м/ |                   |                      | 100,000   | АЗДҮАХ-<br>ийн зардал |
| 5 | Заалны түрээс                                                                                 | 1*5 цаг           | 50,000               | 250,000   | АЗДҮАХ-<br>ийн зардал |
| 6 | Бичиг хэрэг, хэвлэлийн<br>зардал /сургалтын<br>материал, гарын авлага/                        | 60 хүн            | 8,000                | 480,000   | АЗДҮАХ-<br>ийн зардал |
|   | <b>НИЙТ</b>                                                                                   |                   |                      | 4,000,000 |                       |